

Мэргэжлийн болон дээд боловсролын эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Түмэнбаяр Туяацэцэг

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.1. Боловсрол, шинжлэх ухааны хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулах							
1	Дээд болон Мэргэжлийн боловсролын салбарын хүрээнд боловсруулан батлуулах дүрэм журмын боловсруулалтад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.	Мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн дүрэм журмын тоо	-	Холбогдох хуулиар батлах эрх болгосон нийт дүрэм журамд эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Дээд боловсролын тухай хууль /26/ болон Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль /20/-иар эрх олгосон нийт 43 заалтын хүрээнд боловсруулан батлах 43 дүрэм журам, шаардлага, стандартаас дээд боловсролын салбарт 23 дүрэм журам, Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт нийт 12 дүрэм журам буюу нийт 35 дүрэм журмыг Засгийн газрын тогтоол болон БШУСайдын тушаалаар батлахад хууль эрх зүйн хүрээнд хянан эрх зүйн санал дүгнэлт, зөвлөгөө дэмжлэг үзүүлэн ажиллав. Батлагдсан эрх зүйн актын жагсаалтыг хавсралтаар хавсаргав. Эдгээр журмыг хянан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					үзэхдээ доорх шаардлагын хүрээнд хянан үзэв. Үүнд: 1.Нийтлэг шаардлага, 2.Нэр томьёо, хэл зүйн шаардлага, 3.Журамд оруулсан хэм хэмжээ агуулсан зохицуулалт, 4.Журмаар зохицуулах харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан эсэх, 5.Зүйл хэсэг заалт хоорондоо зөрчилтэй эсэх, 6.Журмын бүтэц хэлбэр, 7.Эрх олгосон эрх шилжүүлсэн зохицуулалттай эсэх зэрэг хууль зүйн техник талаас нь илүү нягтлан эрх зүйн санал дүгнэлт өгч ажиллав. Хавсралт: 1 файл		
2	Салбарын хууль эрх зүйн актыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	Дээд болон мэргэжлийн боловсролын салбарын хүрээнд боловсруулан баталсан эрх зүйн актыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан байна	-	Холбогдох салбарын эрх зүйн актыг нийт 100-аас доошгүй хүнд сурталчлах ажлыг зохион байгуулсан байна.	БШУЯ-ны ТНБДаргын 2024 оны А/61 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд "Боловсролын ерөнхий хууль болон түүнийг даган гарсан багц хуулийг сурталчилан таниулах чиг үүрэгтэйгээр ажиллав. Ажлын хэсэг 2024-03-30-2024-04-08-ны өдрүүдэд Баян-Өлгий, Ховд аймагт, 2024-05-05-05-14-ны өдрүүдэд Дундговь, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь аймагт албан томилолтоор ажиллав. Энэ хүрээнд "хөтөлбөр, үнэлгээ, санхүүжилт, багшийн хөгжил, менежмент, цахим шилжилт"-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулав.	3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					Томилолтоор ажиллах хугацаанд нийт 400 гаруй боловсролын салбарын удирдах ажилтан, албан хаагчдад Боловсролын ерөнхий хууль болон түүнийг даган гарсан багц хуулийг сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.		
3	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал , хуулийн төслийг боловсруулах	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал , хуулийн төслийг боловсруулсан байна.	-	Хуульд орсон нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулан байна.	1. Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3.6-ын 1 дэх хэсэгт заасан “Боловсролын зээлийн санг орлогын олон талт эх үүсвэр бүхий Боловсролын хөгжлийн сан болгож, оюутныг дэмжсэн үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэсэн зорилтын хүрээнд, Боловсролын ерөнхий хууль, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагын улмаас өөрчлөхөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.3-т заасны дагуу хуульд	2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулсан. Хуулийн төсөлд “Боловсролын зээлийн сан”-г “Боловсролын хөгжлийн сан” болгон нэрийг өөрчилж, сангийн зориулалтыг дотоод, гадаадад дээд боловсрол эзэмших, ахисан түвшний сургалтад хамрагдах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, зорилтот сургалтад батлагдсан журмын хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр, санхүүжүүлэх арга хэмжээнд багш бэлтгэх, багшийг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтын тэтгэлэг олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх; төрийн албан хаагчийн магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад дэмжлэг үзүүлэх чиглэлээр өөрчлөн тусгасан. Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д “Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан санхүү, төсөв, татварын чиглэлээрх хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран батална” гэж заасны дагуу Сангийн сайдад 2024 оны 1а/11 тоот албан бичгээр хандаж, хуулийн төслийн үзэл	
--	--	--	--	--	--	--

					баримтлалыг батлуулахаар Сангийн яамтай хамтран ажилласан. 3Г-аас уг хуулийг шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор шинэ ажлыг хэсэг байгуулснаар түр түтгэлзээд байна. Хавсралт: 2 файл		
4	Сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал, гэрээ, хэлэлцээрийн төслийг бусад хууль тогтоомжид нийцүүлэн хянах	Сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал, гэрээ, хэлэлцээрийн төслийг бусад хууль тогтоомжид нийцүүлэн хянасан байна.	-	Сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал, гэрээ, хэлэлцээрийн төслийг бусад хууль тогтоомжид нийцсэн байна.	Тайлант хугацаанд Сайд, Төрийн нарийн бичгийн даргын нийт 247 тушаалын төслийг хянаж холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх чиглэлээр зөвлөгөө дэмжлэг үзүүлэв. Үүнээс Сайдын А тушаал-166, Б тушаал-56, Төрийн нарийн бичгийн даргын А тушаал -22, Б тушаал-39 байв.Тушаалын төслийн агуулгыг нарийвчлан тайлагнавал: Ажлын хэсэг байгуулах тухай-50, Зардал батлах тухай -88, Ажилд томилох, ажлаас чөлөөлөх тухай тухай-33, тушаалд өөрчлөлт оруулах тухай-15, гадаад томилолтоор ажиллуулах тухай-33, чөлөө олгох тухай-7, журам батлах тухай-35, эрх шилжүүлэх тухай-4, бусад-39 тушаалын төслийг тус тус хянан зөвлөгөө дэмжлэг үзүүлэв.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Дээд болон мэргэжлийн боловсролын салбарт нийтээр дагаж мөрдөхөөр баталсан	Улсын нэгдсэн санд бүртгүүлсэн захиргааны хэм хэмжээний актын тоо 2. Дээд болон	-	Холбогдох хууль тогтоомжоор эрх олгосон захиргааны хэм хэмжээний акт	Тайлант хугацаанд Дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын салбарын хүрээнд батлагдан гарсан нийт 35 журмыг Захиргааны ерөнхий	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх болон салбарын захиргааны актыг салбарын хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн санд тухай бүр байршуулах	мэргэжлийн боловсролын салбарын хүрээнд баталсан захиргааны актыг салбарын мэдээллийн санд байршуулсан актын тоо		улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн байна. 2. Дээд болон мэргэжлийн боловсролын салбарын хүрээнд баталсан захиргааны акт салбарын мэдээллийн санд байршсан байна.	хуульд заасан хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд тавих баримтын бүрдлийн шаардлагыг ханган ХЗДХЯ-д хүргүүлэн улсын бүртгэлд бүртгүүлэн ажиллав. Улсын бүртгэлд бүртгэгдсэн журмын жагсаалтыг хавсралтаар хавсаргав. Мөн Дээд болон мэргэжлийн боловсролын салбарын хүрээнд баталсан захиргааны актыг цахим сан хариуцсан мэргэжилтэнд и-майлаар хүргүүлэн ажиллав. Хавсралт: 1 файл	сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
6	Боловсрол, шинжлэх ухааны салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалтыг хангаж, салбарын тайланг ХЗДХЯ-д хагас бүтэн жилээр хүргүүлэх.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн зохицуулалт, зохион байгуулалтыг хангаж, 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр ХЗДХЯ-д хүргүүлсэн байна.	-	Салбарын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг ханган ажиллаж, холбогдох тайланг бүтэн жилээр гарган ХЗДХЯ-д хүргүүлсэн байна.	БШУСайдын 2022 оны А/159 дүгээр тушаалаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийг байгуулан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулсан. Уг төлөвлөгөөнд ерөнхий болон нийт 6 тусгай чиглэлийн хүрээнд нийт 21 арга хэмжээг төлөвлөсөн.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр БЕГ-аас гаргуулан биелэлтийг ХЭЗХ-ийн дарга болон ТЗУГ-ын даргад танилцуулан ажиллав. Мөн ГХУСАЗЗ-ийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх,	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тус тус ГХУСЗЗААлбанд хүргүүлэн ажиллав. Холбогдох тайланг нэгтгэн хүргүүлэхээс гадна энэ чиг үүргийн хүрээнд дараах ажлыг зохион байгуулан ажиллав. Үүнд: 1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албанаас 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр "Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл"-ийн ээлжит хуралдааныг зохион байгуулсан. Хуралдаанаар дэд зөвлөлийн 2022 оны тайлан, Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл зэрэг агуулгаар хуралдав. Хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудалд холбогдох санал, тайлан мэдээллийг гаргаж хуралдаанд оролцов. Мөн "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус		
--	--	--	--	--	--	--	--

					эргэлттэй тэмцэх Үндэсний хороо","Терроризмтой тэмцэх зөвлөл"-ийн ээлжит хуралдаанд оролцож ажиллав. Уг хуралдаанаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан ажилласан ба уг төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулан ажиллав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө" түүний дэд зөвлөлийн жилийн тайланг хавсаргав. Хавсралт: 1 файл		
1.2. Хууль, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх							
7	Мэргэжлийн болон дээд боловсролын салбарын хамаарах асуудлаар яаманд холбогдуулан нэхэмжлэгч, хариуцагчаар татагдсан шүүхийн маргаантай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлээр олгосон эрх хэмжээний хүрээнд оролцох, тайлагнах.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлээр олгосон эрх хэмжээний хүрээнд оролцох, тайлагнах.	-	Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн маргаантай хэрэгт оролцсон байна.	Тайлант хугацаанд хавсралтад дурдсан захиргааны болон иргэний нийт 5 хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллав. Дуусгавар болсон 3 хэрэг маргаан / МҮИС-ийн оюутнуудын нэр төрд халдсан нэхэмжлэлтэй болон МУБИС-ийн захирлын сонгон шалгаруулалт, Монгол Германы Ашигтм малтмал технологийн их сургуулийн захирлын сонгон шалгаруулалт, Иргэн Д.Наранцэцэг, Д.Дорждэрэм нартай холбоотой/ хэрэг маргааныг нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон болон нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаасан үндэслэлээр шүүхийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					шийдвэрүүд БШУЯамны буюу хариуцагчийн талд шийдвэрлэгдэв. Тайлангийн биелэлт оруулж буй талбар 2000 тэмдэгтээс илүү оруулж болохгүй байх тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үргэлжилж буй 2 хэрэг маргааны /МҮИС-ийн Удирдах зөвлөлөөс ажил хэргийн нэр хүндэд халдсан болон Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон сайдын тушаалтай холбоотой/ шүүхийн хэрэг шийдвэрлэлтийн явцын талаарх дэлгэрэнгүй тайланг хавсралтаар оруулав. Хавсралт: 6 файл		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Удирдлагын академаас зохион байгуулсан төрийн албан хаагчийн хамрагдвал	Багц сургалтуудад хамрагдсан	-	Холбогдох багц сургалтуудад сууж гэрчилгээ	Удирдлагын академийн төрийн албаны сургуулиас зохион байгуулсан дараах үнэмэлэх	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100%

	зохих 2-оос доошгүй сургалтад хамрагдаж холбогдох гэрчилгээг авч ажиллана.	байна.		авсан байна.	олгох сургалтуудад хамрагдаж ажиллав. Үүнд: 1. "Төрийн чадамжийг бүрдүүлэх нь" сэдэвт нийт 24 цагийн хичээлийг судлан №24/0216 тоот үнэмлэхийг авч ажиллав. Хичээлийн сэдэвт дараах агуулгыг хамаарч судлав. /Төрийн чадамжийн тухай ойлголт, Асуудлыг тодорхойлох, задлах, дараалуулах, Загварчлах орон зайг ашиглан шийдлийг олох, Эрх мэдлээ бүрдүүлэх, Давтацаа загварчлах, Туршилтын үр дүнгээ хэлэлцэх/. 2.Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт /Том зургаар харах/ сэдэвт цахим сургалтад хамрагдаж үнэмлэх авч ажиллав. 3. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт /Нэгжийн түвшинд жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх нь/ сэдэвт сургалтад хамрагдав. Холбогдох баримтыг хавсаргав. Хавсралт: 1 файл		Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Хууль тогтоомж боловсруулах арга техник, хууль зүйн техникийн хэрэглээ болон гэрээний эрх зүй чиглэлээр бичигдсэн тус бүр 1-ээс доошгүй онолын болон эрдэм шинжилгээний бүтээл уншиж судлаж ур чадвараа хөгжүүлнэ.	Холбогдох ном зохиолыг уншин судалсан байна.	-	Холбогдох ном зохиолыг уншин судалсан байна.	М.Тайширын "Хуулийн төсөлд эрх зүйн дүгнэлт хийх арга зүй" гарын авлага болон Л.Банзрагч "Гэрээний эрх зүйн онол арга зүй" ,"Гэрээний зарим эрх зүйн маргааны хууль хэрэглээ болон гэрээг цуцлах гэрээнээс татгалзахад анхаарах асуудал" Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмжийг тус тус судлан ажиллав.	10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэргэжлийн болон дээд боловсролын эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Түмэнбаяр Туяацэцэг
/...../ Огноо: